



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Иргэдийн өргөдөл, гомдлыг
шуурхай шийдвэрлэх Штаб
байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн захирамж, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 2/5524 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор төвийн Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх Штабын бүрэлдэхүүнийг 1, гүйцэтгэх чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, энэ тухайгаа Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх Штабт тухай бүр мэдээлэхийг нийт ажиллагсдад, мэдээг Эрүүл мэндийн яаманд өдөр бүрийн 16.00 цагт цахимаар хүргэж ажиллахыг Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх Штабын Нарийн бичиг /Е.Алтанжимс/-т тус тус үүрэг болгосугай.


3. Иргэдэд хүндрэл, чирэгдэл, бухимдал үүсгэхгүй ажиллахыг нийт ажиллагсдад уриалсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 12 дугаар сарын 09-ний
өдрийн 11/28 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭХ
ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Штабын дарга: Ерөнхий захирал /Н. Эрдэнэбаяр/
Гишүүд: Цусны чанар, аюулгүй байдлын албаны даргын үүрэг
гүйцэтгэгч /А.Амарзаяа/
Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/
Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны
дарга /Б.Солонго/
Үйлдвэрлэлийн тасгийн Эрхлэгч /Б.Оргил/
Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/
Нарийн бичиг: Захиргаа, маркетингийн албаны Архив, бичиг хэргийн
эрхлэгч /Е.Алтанжимс/

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 12 дугаар сарын 09-ний
өдрийн 17:38 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

1118266548 9128305

ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭХ ШТАБЫН ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, Иргэдэд хүндрэл, чирэгдэл, бухимдал үүсгэхгүй байх чиглэлээр Шуурхай штаб дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Өргөдөл, гомдлыг төвийн Ажлын цагаар **70112857**, Ажлын бус цаг, амралтын өдөр **70136504**, **88326503** дугаарын утсаар хүлээн авах ажлыг зохион байгуулах;

2. Ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох ажилтанд шилжүүлэн боломжит богино хугацаанд хариуг бэлдэн, хүргүүлж, мэдээг Штабт ирүүлэх ажиллагааг зохион байгуулан хяналт тавих;

3. Төвийн гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээнд хамаарахгүй өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэн энэ талаар өргөдөл, гомдол гаргагчид мэдээлэх;

4. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллагад шуурхай шилжүүлж, энэ талаар өргөдөл, гомдол гаргагчид мэдээлэх;

5. Өргөдөл, гомдлын мэдээ өдөр бүрийн 16.00 цагаас өмнө штабын даргад танилцуулан, 16.00 цагт Эрүүл мэндийн яамны Шуурхай штабт emy@moh.gov.mn цахим хаягаар дараах ажилтан хариуцаж хүргүүлэх:

5.1. Ажлын өдрийн 16.00 цагт Штабын нарийн бичгийн дарга Э.Алтанжимс;

5.2. Амралтын өдрийн 16.00 цагт Штабын гишүүн Б.Оргил хариуцаж, Олгох хэсгийн сувилагч.

6. Өргөдөл, гомдлын мэдээ өдөр бүрийн мэдээг штабын гишүүдэд telegram аппликейшний ЦССҮТ-adminstration хаягт хүргүүлнэ.

7. Штабын гишүүд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, иргэдэд хүндрэл, чирэгдэл, бухимдал үүсгэхгүй байх чиглэлээр ажиллагсдад үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.